

ДОТООД ЖУРАМ ДУГААР 1

**ЭРДЭНЭ ГОУЛД КОРПОРАЦИЙН АЛБАН ХЭЛЦЭЛ, ГҮЙЛГЭЭ, АЖИЛ ХЭРЭГТ
МӨРДӨГДӨХ ЕРӨНХИЙ ЖУРАМ**

*"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн,
баталгаажуулав.*

*Утас: 89100044; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN***

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

АГУУЛГА

БҮРТГЭЛТЭЙ АЛБАН ЁСНЫ БАЙГУУЛЛАГА.....	4
ТАМГА ТЭМДЭГ.....	4
САНХҮҮГИЙН ЖИЛ.....	4
БАНКНЫ ЗОХИЦУУЛАЛТ.....	4
ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ.....	5
ЕРӨНХИЙ ЗАХИРЛУУД.....	5
ЗАХИРЛУУДЫН ТОО БА ИРЦ.....	5
ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	5
КАНАД ИРГЭД.....	6
СОНГУУЛЬ БА АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ ХУГАЦАА.....	6
ЗАХИРЛЫГ ОГЦРУУЛАХ.....	6
СУЛ ОРОН ТОО.....	7
ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ.....	7
ЭЭЛЖИТ ХУРАЛ.....	7
ШИНЭ ТУЗ-ИЙН АНХНЫ ХУРАЛ.....	8
ХУРЛЫН БАЙРШИЛ.....	8
ХУРАЛД УТСААР ОРОЛЦОХ.....	8
САНАЛААР ШИЙДВЭРЛЭХ.....	8
ЗАХИРЛУУДЫН ЦАЛИН.....	8
АЛБАН ХЭРГИЙГ ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛАХ.....	9
ГАНЦ ЗАХИРАЛТАЙ БАЙХ.....	9
АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ.....	9
ЗАЙЛСХИЙХ СТАНДАРТ.....	Error! Bookmark not defined.
ЗАХИРЛУУД БА АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛАХ.....	11
ЗАХИРЛУУД БА АЖИЛТНУУДЫН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ.....	11
ДЕРИВАТИВ ҮЙЛДЛИЙН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ.....	11
НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ.....	12
ЗАХИРАЛ БОЛОН АЖИЛТНУУДЫН ДААТГАЛ.....	12
ДОТООД ТАЙЛАН.....	12
ХУРЛЫН МЭДЭГДЭЛ.....	12
ЗАХИРЛУУДЫН АУДИТЫН ХОРОО.....	13
БУСАД ХУРАЛД КОРПОРАЦИЙГ ТӨЛӨӨЛӨХ.....	13
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН БУСАД ЭТГЭЭДЭД ЗЭЭЛ ОЛГОХ.....	13
АЛБАН ТУШААЛТНУУД.....	13
АЛБА ХАШИХ ХУГАЦАА БА ЦАЛИН.....	14
ТУЗ-ИЙН ДАРГА.....	14
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ.....	14
ЕРӨНХИЙЛӨГЧ.....	15
ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ.....	15
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР.....	15
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА.....	15
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ.....	16
БУСАД АЛБАН ТУШААЛТНУУД.....	16
ЭРХ ҮҮРГИЙН ӨӨРЧЛӨЛТ.....	16
АГЕНТ БА ӨМГӨӨЛӨГЧ.....	16
ҮНЭНЧ БАЙДЛЫН ҮҮРЭГ АМЛАЛТ.....	16

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ХУВЬЦАА ХУВААРИЛАХ.....	17
ШИМТГЭЛ ТӨЛӨХ.....	17
ХУВЬЦААНЫ ГЭРЧИЛГЭЭ.....	17
ХУВЬЦААНЫ ГЭРЧИЛГЭЭГ СОЛИХ.....	18
ТӨВИЙН БОЛОН САЛБАРЫН БҮРТГЭГЧ.....	18
ҮНЭТ ЦААС ШИЛЖҮҮЛЭХ.....	18
БҮРТГЭГДСЭН ЭЗЭМШИГЧТЭЙ АРИЛЖАА ХИЙХ.....	18
ХАМТРАН ЭЗЭМШИГЧ.....	19
БҮРТГЭЛИЙН ОГНОО.....	19
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЖИЛ БҮРИЙН ХУРАЛ.....	19
ТУСГАЙ ХУРАЛ.....	Error! Bookmark not defined.
МЭДЭГДЭЛ.....	20
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАЙЛАГНАХ.....	21
БАЙЛЦАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД.....	21
ХУРЛЫН ИРЦ.....	21
САНАЛЫН ЭРХ.....	21
ТӨЛӨӨЛӨГЧ.....	22
ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ.....	22
ХАМТАРСАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ.....	23
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА.....	23
САНАЛ ТООЛОГЧ.....	23
САНАЛААР ШИЙДВЭРЛЭХ.....	23
ГАР ӨРГӨХ.....	23
НУУЦ САНАЛ ХУРААЛТ.....	24
ШИЙДВЭРЛЭХ САНАЛ.....	24
ХУРЛЫГ ХОЙШЛУУЛАХ.....	25
ШИЙДВЭРИЙГ ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛАХ.....	25
ГАНЦ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ.....	25
НОГДОЛ АШИГ БОЛОН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ОГНОО.....	25
НОГДОЛ АШИГ.....	26
МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ АРГУУД.....	26
ХУГАЦАА ТООЦООЛОЛ.....	27
ЭС ҮЙЛДЭХҮЙ БА АЛДАА.....	27
ХАМТАРСАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ.....	27
НАС БАРСАН ЭТГЭЭДИЙН ЭСХҮЛ ХУУЛЬД ЗААСАН ЭЗЭМШИГЧИЙН ЭРХЭЭС ҮЛ ШАЛТГААЛАН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ.....	27
МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВААГҮЙ БАЙХ.....	28
МЭДЭГДЭЛ ДЭЭРХ ГАРЫН ҮСЭГ.....	28
МЭДЭГДЛЭЭС ТАТГАЛЗАХ.....	28
ТУСГААР БАЙДАЛ.....	29
ТАЙЛБАР.....	29

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн,
баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

КОРПОРАЦИЙН ЖУРАМ ДУГААР 1

ЭРДЭНЭ ГОУЛД КОРПОРАЦИЙН АЛБАН ХЭЛЦЭЛ, ГҮЙЛГЭЭ, АЖИЛ ХЭРЭГТ МӨРДӨГДӨХ ЕРӨНХИЙ ЖУРАМ

Энэхүү журмыг Эрдэнэ гоулд корпорацийн (цаашид “Корпораци” гэх) журам болгон дараах байдлаар батласугай. Үүнд:

БҮРТГЭЛТЭЙ АЛБАН ЁСНЫ БАЙГУУЛЛАГА

1. Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь тухай бүрт тогтоол гарган Корпорацийн дүрэмд заасан газарт, Канад улс дотор Корпорацийн байрлах албан ёсны бүртгэлтэй хаягийг тодорхойлно.

ТАМГА ТЭМДЭГ

2. Корпораци нь тамга тэмдэгтэй байж болох ба түүнийг ТУЗ-ийн тогтоолоор баталж, өөрчилнө.

САНХҮҮГИЙН ЖИЛ

3. Корпорацийн санхүүгийн эхний жил нь Корпорацийн ТУЗ-ийн тогтоосон өдрөөр дуусгавар болж, түүнээс хойш Корпорацийн ТУЗ-ийн шийдвэрээр өөрчлөх хүртэл жил бүрийн тухайн өдрөөр дуусгавар болно.

БАНКНЫ ЗОХИЦУУЛАЛТ

4. Корпораци, түүний аливаа хэсгийн банкны хэлцэл, гүйлгээг тухай бүрт ТУЗ-ийн гаргах тогтоолоор сонгон, томилж, эрх олгосон ийм үйл ажиллагаа явуулдаг банк, итгэлцлийн компани, бусад фирм эсхүл корпорациар дамжуулан хийж гүйцэтгэх ба Корпорацийн нэрийн өмнөөс банкны хэлцэл, гүйлгээ, түүний аливаа хэсгийг тухай бүрт ТУЗ-ийн тогтоолоор томилж, даалгаж, эрх олгосон нэг эсхүл хэд хэдэн албан тушаалтан ба/буюу бусад этгээд нь дээр заасан ерөнхий зарчмыг хязгаарлахгүйгээр энд тодорхойлсон эрх хэмжээний хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - a. Корпорацийн дансны үйл ажиллагаа;
 - b. Аливаа чек, энгийн вексель, шилжих вексель, акцепт, вексель шилжүүлэх, мөнгөн төлбөрийн захиалга;
 - c. Корпорацийн аливаа эд хөрөнгөтэй холбоотой баримт, мэдүүлгийг өгөх;

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

- d. Банкны аливаа хэлцэл, гүйлгээтэй холбоотой гэрээ хэлцэл байгуулах, гэрээний талуудын эрх, хэмжээг тодорхойлох;
- e. Банкны тухайн хэлцэл, гүйлгээг хялбаршуулах үүднээс банкны ажилтанд Корпорацийн нэрийн өмнөөс аливаа үйлдэл эсхүл зүйл хийх эрх олгох.

ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ

- 5. Корпорацийн гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагатай бичгээр үйлдсэн аливаа хэлцэл, шилжүүлэг, томилгоо, гэрээ, үүрэг болон бусад баримт бичгүүдэд Корпорацийн нэрийн өмнөөс гарын үсэг зурж, тамга дарах эрх бүхий этгээд гарын үсэг зурж баталгаажуулан тамга тэмдэг дарж болно. ТУЗ нь Корпорацийн дотоод журамд агуулагдах аливаа эсрэг заалтыг үл хамааран ямар ч үед, тухай бүрт Корпорацийн гарын үсэг зурж баталгаажуулах шаардлагатай эсхүл гарын үсэг зурж баталгаажуулах бичгээр үйлдсэн тодорхой эсхүл аливаа ангиллын хэлцэл, шилжүүлэг, томилгоо, гэрээ, үүрэг болон бусад баримт хэрэглүүрт гарын үсэг зурж, баталгаажуулах этгээд эсхүл хэд хэдэн этгээдийг томилсон тушаалыг гаргана.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛУУД

- 6. Захирлууд нь Корпорацийн албан үйл ажиллагаа, үйл хэргийг удирдана.

ЗАХИРЛУУДЫН ТОО БА ИРЦ

- 7. Корпорацийн дүрэм ёсоор Корпорацийн захирлуудын тоо нь тус дүрмээр зөвшөөрсөн хамгийн бага болон их хязгаарын хүрээнд тухай бүрт ТУЗ-өөс тогтоон тодорхойлсон тоо байна. Дүрмийн 9 дүгээр зүйлийн дагуу захирлуудын аливаа хуралд оролцон албан хэлцэл хийх ирц нь албан тушаал хашиж буй захирлуудын олонхи эсхүл тухай бүрт ТУЗ-өөс тодорхойлсон тооны захирлуудаас бүрдэнэ. Сул орон тоог үл хамааран одоо байгаа захирлууд нь ТУЗ-ийн ирц бүрдэх хүртэл ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлж болно.

ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 8. Захирал нь арван найм (18) ба түүнээс дээш настай байх бөгөөд дампуурсан, сэтгэцийн хувьд хэвийн бус эсхүл ийм болох нь Канад улсын болон өөр бусад шүүхээр тогтоогдсон, хувь хүн бус этгээдийг захирлаар томилохгүй. Хэрэв

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

захирал нь дампуурсан эсхүл сэтгэцийн хувьд хэвийн бус болсон, эсхүл ийм болох нь тогтоогдсон бол түүнийг захирлын албан тушаалаас чөлөөлнө.

КАНАД ИРГЭД

9. Захирлуудын тавиас (50%) доошгүй хувь нь Канадын иргэд (Корпораци дөрвөөс (4) цөөн захиралтай бол түүний хоёроос (2) доошгүй захирал нь Канадын иргэд байна) байх ба хуралд оролцож буй захирлуудын хоёрны нэг (1/2) нь Канад иргэд биш бол ТУЗ аливаа албан хэлцэл хийхгүй. Хуралд оролцож буй захирлуудын хоёрны нэгээс бага (1/2) нь Канад иргэд байх тохиолдолд, хэрэв:
- a. Канадын иргэн захирал хуралд оролцох боломжгүй тохиолдолд хурал дээр яригдах албан хэлцлийг бичгээр, утсаар эсхүл харилцаа холбооны өөр хэрэгслээр зөвшөөрсөн;
 - b. Хуралд оролцож буй Канадын иргэн захирлуудын тоо, энэхүү заалтын а. Хэсэгт заасан дагуу зөвшөөрөл өгсөн Канадын иргэн захирлуудын тоотой нийлээд хуралд ирсэн нийт захирлуудын хоёрны нэг (1/2)-ээс доошгүй байвал захирлууд өмнө дурдсан заалтыг үл хамааран ТУЗ-ийн хурлаар албан хэлцэл хийж болно..

СОНГУУЛЬ БА АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ ХУГАЦАА

10. Захирлуудыг Корпорацийн ТУЗ-ийн дараа жилийн ээлжит хурал хуралдах хүртэл, эсхүл залгамжлагчийг сонгох хүртэл жилийн хугацаатай сонгоно. ТУЗ-ийн дараа жилийн ээлжит хуралдаанаар ТУЗ-ийг бүхэлд нь сонгох ба алба хашиж байсан бүх захирлууд огцрох бөгөөд шаардлага хангасан захирлууд дахин сонгуульд орох эрхтэй байна. Хувьцаа эзэмшигч нууцаар санал хураалт явуулах шаардлага тавиагүй тохиолдолд сонгуулийг гар өргөх зарчмаар эсхүл хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр явуулна.

ЗАХИРЛЫГ ОГЦРУУЛАХ

11. Захирлыг огцруулах тухай тусгайлан заасан мэдэгдлийг хүргүүлсний үндсэн дээр зарлагдсан хувьцаа эзэмшигчдийн тусгай хуралдаанаар захирал эсхүл захирлуудыг албан үүрэгт хугацаа нь дуусгавар болохоос өмнө олонхийн шийдвэрлэх саналаар огцруулах шийдвэрийг гаргаж, тухайн хуралд оролцсон олонхийн шийдвэрлэх саналаар огцорч буй захирлын албан тушаалыг албан үүрэгт хугацаа нь дуусгавар болох хүртэл үргэлжлүүлэх орны этгээдийг сонгож болох бөгөөд орны этгээдийг сонгож чадаагүй тохиолдолд сул орон тоонд ажиллах захирлыг ТУЗ томилно.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

СУЛ ОРОН ТОО

12. Захирлуудын байх ёстой хамгийн бага тоо хэмжээ өссөн эсхүл Дүрэм ёсоор захирлуудын байвал зохих хамгийн доод тоо хэмжээнд хүртэл захирал сонгож чадаагүйгээс бусад тохиолдолд ирц бүрдүүлэх үүднээс шаардлага хангасан этгээдийг ТУЗ дахь эзгүй орон тоонд албан үүргийн үлдсэн хугацааны туршид ажиллуулахаар сонгож болно. Хэрэв захирлуудын ирц бүрдэхгүй, эсхүл захирлуудын байх ёстой хамгийн бага тоо хэмжээ өссөн, эсхүл Корпорацийн дүрэм ёсоор захирлуудын байвал зохих хамгийн доод тоо хэмжээнд хүртэл захирал сонгож чадаагүйгээс сул орон тоо бий болсон тохиолдолд албан тушаал хашиж буй захирлууд хувьцаа эзэмшигчдийн тусгай хуралдааныг зарлан хуралдуулж, сул орон тоог нөхөх ба хурал зарлан хуралдуулж чадаагүй эсхүл байгууллагад өөр захирал үлдээгүй тохиолдолд аль ч хувьцаа эзэмшигч тусгай хурлыг зарлан хуралдуулж болно.

ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ

13. ТУЗ-ийн хурлыг Ерөнхийлөгч эсхүл захирал болох Дэд ерөнхийлөгч, эсхүл аливаа хоёр (2) захирлын тогтоосон өдөр, цаг, байршилд тухай бүрт хуралдуулах ба Ерөнхийлөгч эсхүл захирал болох Дэд ерөнхийлөгч, эсхүл аливаа хоёр (2) захирлын тушаал, зааварчилгаа ёсоор Нарийн бичгийн дарга хурлыг зарлана. Бүх захирлууд байлцаж, хурал хуралдуулахыг эсэргүүцээгүй, эсхүл өөрийн биеэр байлцаагүй ч ийм хурал хуралдуулахыг зөвшөөрч, түдгэлзүүлэхгүй болохоо мэдэгдсэн бол хурал зарлан хуралдуулах мэдэгдэл хүргүүлэх шаардлагагүйгээс бусад тохиолдолд хурал зарлан хуралдуулах хурлын мэдэгдлийг захирал бүрт тухайн хурал болохоос өмнө дөчин найман (48) цагаас багагүй хугацаанд (хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Канадын Хуулийн тайлбар актад тодорхойлсон Ням гараг эсхүл баярын амралтыг үүнд оролцуулахгүй) хүргүүлнэ. Хэрэв анхны хурал дээр хойшлогдсон хурлын товыг зарласан бол ТУЗ-ийн хойшлогдсон хурлыг зарлан хуралдуулах тухай мэдэгдэл хүргүүлэх шаардлагагүй. Хурал зарлан хуралдуулах мэдэгдэлд хурлын үеэр хэлэлцэх асуудал, хурлын зорилгыг (хурлын зорилго, хэлэлцэх асуудлыг заасан байхыг хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд) нарийвчлан заах шаардлагагүй.

ЭЭЛЖИТ ХУРАЛ

14. ТУЗ нь аль ч сарын, аль ч өдрийг ээлжит хурал хуралдуулах өдрөөр товлож болох ба хурал болох байршил, цагийг заана. ТУЗ-ийн ээлжит хурлын цаг, байршлыг товлосон тухай ТУЗ-ийн тогтоол батлагдмагц түүний хуулбарыг бүх захирлуудад хүргүүлэх ба хурлын үеэр хэлэлцэх асуудал, хурлын зорилгыг заахыг Хуулиар эсхүл энэхүү журмаар тусгайлан шаардсанаас

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

бусад тохиолдолд ийм ээлжит хурлын талаар өөр бусад мэдэгдэл хүргүүлэх шаардлагагүй.

ШИНЭ ТУЗ-ИЙН АНХНЫ ХУРАЛ

15. Шинээр сонгогдсон ТУЗ нь тус ТУЗ-ийг сонгосон хувьцаа эзэмшигчдийн хурлын дараагаар захирлуудын ирц бүрдсэн тохиолдолд албан тушаалтнуудыг сонгон томилох, зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх зорилгоор анхны хурлаа зарлан хуралдуулж болно.

ХУРЛЫН БАЙРШИЛ

16. ТУЗ-ийн хурлыг Корпорацийн албан ёсны бүртгэлтэй оффисийн байр, эсхүл Канад Улсад эсхүл Канад Улсаас гадна өөр бусад газар хуралдуулж болно.

ХУРАЛД УТСААР ОРОЛЦОХ

17. Захирал нь утас эсхүл хуралд оролцогч бүх этгээд бие биенээ сонсож болохоор харилцаа холбооны бусад зөвшөөрөгдөх хэрэгслээр дамжуулан оролцож болох ба утсаар хуралд оролцож буй захирлыг хуралд байлцсан гэж үзнэ.

САНАЛААР ШИЙДВЭРЛЭХ

18. ТУЗ-ийн бүх хурлаар шийдвэрлэгдэх асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх ба санал тэнцсэн тохиолдолд хурлын дарга хоёр дахь санал хураалт явуулах эсхүл шийдвэрлэх саналын эрхтэй байна.

ЗАХИРЛУУДЫН ЦАЛИН

19. Корпорацийн захирлуудын цалингийн хэмжээг ТУЗ тогтооно. Корпорацийн ажилтан эсхүл албан тушаалтан, Корпорацийн зөвлөх эсхүл өмгөөлөгч, эсхүл Корпорацид ямарваа мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчээр ажилладаг захирлын цалин нь түүний эрхэлдэг албан тушаалын эсхүл үзүүлсэн үйлчилгээний хөлсөн дээр нэмэгдэж тооцогдоно. Түүнчлэн захирлуудад зөвлөлийн, хорооны, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, эсхүл ТУЗ-өөс тухай бүрт тодорхойлсон ажил үүргийг гүйцэтгэхтэй холбоотойгоор хувиас нь гарсан зардлыг нөхөн олгоно. Тодруулбал, энэхүү заалт нь аливаа захирлыг Корпорацид өөр бусад байдлаар хүчин зүтгэж, цалин авахыг хязгаарлахгүй.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

АЛБАН ХЭРГИЙГ ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛАХ

20. ТУЗ-ийн хурлаас гаргах бичгээр үйлдсэн тогтоолд саналын эрхтэй бүх захирлууд гарын үсэг зурснаар тус тогтоолыг тухайн зорилгоор зарлагдан хуралдсан ТУЗ-ийн хурлаар батлагдсан, хүчин төгөлдөр тогтоол гэж үзнэ. Ийм тогтоолын хуулбарыг ТУЗ-ийн эсхүл хороодын хурлын тэмдэглэлийн хамт хадгална. Бичгээр үйлдсэн аливаа тогтоол нь тус тогтоол, түүний хувиудад хэзээ гарын үсэг зурж баталгаажуулснаас үл хамаарч тогтоолын заасан зорилго, хугацааны турш хүчин төгөлдөр байна.

ГАНЦ ЗАХИРАЛТАЙ БАЙХ

21. Корпораци ганц захиралтай байх тохиолдолд тус захирал нь Корпорацийн бизнесийн үйл ажиллагаа, ажил хэргийг удирдан явуулах бөгөөд 20 дугаар зүйлд заасан дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн бүх албан хэргийг тус захирал хөтлөн явуулна.

АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ

22. Корпорацитай материаллаг гэрээ байгуулсан эсхүл материаллаг гэрээ санал болгосон захирал, ажилтан бүр, Корпорацитай байгуулсан эсхүл санал болгосон материаллаг гэрээний тал болох аливаа этгээдийн захирал, ажилтан, эсхүл эсхүл ийм этгээдэд материаллаг сонирхолтой захирал, ажилтан нь өөрийн ашиг сонирхлын шинж чанар, хэмжээ хүрээг Корпорацид бичгээр мэдүүлэх буюу захирлуудын хурлын тэмдэглэлд оруулах хүсэлтээ гаргана. Бүх ийм мэдүүлгийг Канад улсын Бизнес корпорацийн Хуулийн үйлчлэх заалтад шаардсан хугацаанд гаргаж өгөх ба Канад улсын Бизнес корпорацийн Хуулиар хориглосон тохиолдолд захирлууд материаллаг гэрээ, санал болгосон материаллаг гэрээтэй холбоотойгоор санал өгөх эрхгүй байна.

ХҮЧИНГҮЙД ТООЦОХ ТУХАЙ

23. Хэрэв захирал нь энэхүү журмын 22 дугаар заалтын дагуу ашиг сонирхлоо мэдүүлсэн, Корпораци ба түүний нэг буюу хэд хэдэн захирал эсхүл ажилтнуудын хооронд байгуулсан, эсхүл Корпораци ба Корпорацийн захирал эсхүл ажилтан нь өөр этгээдийн захирал нь эсхүл ажилтан нь хоорондоо байгуулсан материаллаг гэрээ, уг захирал эсхүл ажилтан нь материаллаг ашиг сонирхол бүхий материаллаг гэрээг ТУЗ эсхүл Хувьцаа эзэмшигчид батласан, ийнхүү батлах нь тухайн үедээ Корпорацийн хувьдхууль ёсны бөгөөд шударга байсан тохиолдолд захирал ба ажилтны дээрх харилцаанаас

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

шалтгаалж, эсхүл гэрээнд ашиг сонирхолтой болохоо илэрхийлсэн захирал нь уг гэрээг батласан ТУЗ-ийн хурлын ирцэд байлцсан гэдэг шалтгаанаар дээрх гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэхгүй.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ЗАХИРЛУУД БА АЖИЛТНУУДЫГ ХАМГААЛАХ

24. Корпорацийн нэрийн өмнөөс ТУЗ-ийн тушаалаар эзэмшилдээ авсан аливаа өмчийн эрх хангалтгүй эсхүл дутагдалтай байснаас эсхүл Корпорацийн мөнгө, үнэт цаас, хөрөнгийг хадгалагч этгээдийн дампуурал, төлбөрийн чадвар алдагдалт, гэм хортой үйлдлээс үүдэн бий болсон алдагдал, хохирлоос, Корпорацийн хөрөнгийг оруулах үнэт цаас дутагдалтай; хангалтгүй байснаас; шийдвэр гаргалт, хяналтын алдаанаас үүдсэн хохирол; ажил үүргээ гүйцэтгэх явцад; ажил үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор учирсан аливаа хохирол, гарз, золгүй явдлаас үүдэн Корпорацид учирсан аливаа зардал, хохирол эсхүл нийцлийн бусад үйлдэл, хүлээн авалтад оролцсон нь Канадын Бизнесийн байгууллагын хууль эсхүл өөр бусад хууль тогтоомжийн дагуу үүрэг, хариуцлагаа зөрчсөний улмаас шүүх хурал, шүүн таслах ажиллагаа явагдахад хүргэсэн өөр бусад захирал эсхүл ажилтны үйлдэл, хүлээн авалт, тоомжиргүй байдал, үүргээ зохих ёсоор биелүүгээгүй байдалд Корпорацийн ямар ч захирал эсхүл ажилтан хариуцлага хүлээхгүй.

ЗАХИРЛУУД БА АЖИЛТНУУДЫН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ

25. Корпораци нь:

- a. Корпорацийн ашиг сонирхлыг дээдлэн үнэнч шударгаар, зүй зохистой ажилласан;
- b. Мөнгөн торгууль оногдуулсан эрүүгийн болон захиргааны шүүн таслах ажиллагааны үед өөрийн үйлдлийг хууль ёсны болохыг үндэслэлтэйгээр батласан

Корпорацийн одоогийн болон өмнөх захирлууд, ажилтнууд, Корпорацийн хүсэлтээр Корпорацийн хувь эзэмшдэг байсан эсхүл зээлдүүлэгч асан байгууллагын захирал, ажилтнаар ажилласан болон ажиллаж буй аливаа этгээд, тэдгээрийн залгамжлагч, хуулийн төлөөлөгчдийг уг Корпораци эсхүл хувь эзэмшдэг байгууллагын захирал эсхүл ажилтан байсных нь төлөө аливаа иргэн, эрүү, захиргааны үйл ажиллагаа, шүүн таслах ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг шийдвэрлэх, шийдвэр хангуулахад оролцуулснаас учрах бүх зардал, төлбөр, торгуулийг нөхөж барагдуулна.

ҮҮСМЭЛ ҮЙЛДЛИЙН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ

26. Корпораци нь шүүхийн зөвшөөрлөөр (Канадын Бизнесийн байгууллагын хуульд тодорхойлсончлон) Корпорацийн, түүний нэрийн өмнөөс эсхүл бусад байгууллагын үйлдсэн үйлдэлтэй холбоотойгоор Корпораци эсхүл хувь эзэмшдэг байгууллагын захирал эсхүл ажилтан байсан, шүүхэд татагдсан бөгөөд Корпорацийн талд шийдвэр гаргуулсан энэхүү журмын 25 дугаар заалтад заасан этгээд нь уг заалтын а болон б хэсэгт тодорхойлсон

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

нөхцөлийг хангасан тохиолдолд уг үйл ажиллагаатай холбоотойгоор тэдгээрт учирсан бүх зардал, төлбөр, торгуулийг нөхөж барагдуулж болно.

НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ

27. Корпораци нь энэхүү журмын 25, 26 дугаар заалтаас үл хамааран 25 дугаар зүйлд заасан Корпораци эсхүл хувь эзэмшдэг байгууллагын захирал эсхүл ажилтан байсны төлөө иргэн, эрүү, захиргааны шүүх ажиллагаанд татагдан орж, амжилттай хамгаалалт хийж чадсан 25 дугаар зүйлд заасан этгээдийн дээрх үйл ажиллагаа, шүүх хуралтай холбоотойгоор түүнд учирсан бүх зардал, төлбөр, торгуулийг нөхөж барагдуулна.

ЗАХИРАЛ БОЛОН АЖИЛТНУУДЫН ДААТГАЛ

28. Корпораци нь энэхүү журмын 25 дугаар заалтад тодорхойлсон аливаа этгээдийг харьцуулж болох нөхцөл байдалд хянамгай сэрэмжтэй этгээд ур чадвар, мэргэжлийн чадавхи, хянуур болгоомжтой байдлаа ашиглаж чадаагүйгээс учрах эсхүл тохиолдох аливаа хариуцлага, зардал, төлбөр, торгуулиас сэргийлж даатгуулж болно.

ДОТООД ТАЙЛАН

29. ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгч, Нарийн бичгийн дарга эсхүл Корпорацийн туслах Нарийн бичгийн дарга нь тус тус Канадын Бизнесийн байгууллагын хууль болон аливаа үйлчлэх хууль тогтоомжийн дагуу Корпорацийн тайлагнах шаардлагатай аливаа дотоод тайланд Корпорацийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах эрхтэй байна.

ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

30. ТУЗ-ийн дарга, Ерөнхийлөгч, нарийн бичгийн дарга, Корпорацийн туслах Нарийн бичгийн дарга, Ерөнхий нягтлан бодогч нар нь тус тус дараах мэдэгдэлд гарын үсэг зурах эрхтэй байна. Үүнд:

- a. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн агуулга болон уг мэдэгдлийг илгээхийг Удирдлага болон ТУЗ зөвшөөрсөн мэдэгдэл;
- b. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд мэдэгдлийн хувийг захирал, аудитор, Корпорацийн хувьцаа эзэмшигч бүрт урьдчилсан төлбөрт шуудангаар илгээсэн болохыг гэрчлэх Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг дагалдах мэдэгдэл.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ЗАХИРЛУУДЫН АУДИТЫН ХОРОО

31. Корпораци нийтэд зориулан үнэт цаас гаргах бүрт захирал нь захирлуудын тооноос хамаарч гурваас (3) доошгүй тооны захирлыг Аудитын хороогоор томилон ажиллуулах ба тус хорооны олонхи нь Корпораци, түүний хамааралтэй этгээдийн ажилтнууд, албан хаагчид байж болохгүй. Аудитын хороо нь Канадын Бизнесийн байгууллагын хууль, түүнийг дагалдах хууль тогтоомжид заасан болон захирлуудын даалгасан нэмэлт үүргийг гүйцэтгэнэ.

БУСАД ХУРАЛД КОРПОРАЦИЙГ ТӨЛӨӨЛӨХ

32. ТУЗ-ийн дарга эсхүл түүний бичгээр томилсон аливаа этгээд, хэрэв ийм этгээд байхгүй бөгөөд ийнхүү томилж чадаагүй тохиолдолд Корпорацийн байгууллагын тамга тэмдэг бүхий бичмэл баримтаар төлөөлөх эрх олгогдсон этгээд нь Корпорацийн хувьцаа эзэмшдэг аливаа корпорацийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Корпорацийг төлөөлнө.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН БУСАД ЭТГЭЭДЭД ЗЭЭЛ ОЛГОХ

33. Корпорацийн захирлууд нь зээл, батлан даалт хэлбэрээр тухай бүрт санхүүгийн туслалцааг дараах тохиолдолд үзүүлж болно. Үүнд:
- a. Корпорацийн өмнөөс учирсан эсхүл учирч болзошгүй зардлаас шалтгаалж;
 - b. Хэрэв Корпораци нь толгой компанийн бүрэн эзэмшилд байдаг охин компани бол толгой компанид;
 - c. Корпорацийн охин компанид;
 - d. Корпорацийн хамааралтай аливаа этгээдийн ажилтнуудад тэдгээрийг хувьцаа эзэмшигч эсхүл захирал эсэхээс үл хамааран:
 - i. Ажил үүргээ гүйцэтгэхийн тулд амьдрах орон байр худалдан авах, барихад нь туслалцаа үзүүлэх;
 - ii. Итгэмжлэгдсэн этгээдэд хадгалагдаж буй Корпорацийн хамааралтай этгээд эсхүл Корпорацийн хувьцааг худалдан авах төлөвлөгөөний дагуу.
 - e. Корпорацийн зүгээс санхүүгийн туслалцаа үзүүлсний дараа төлбөрөө хугацаандаа төлж чадахгүй гэх хангалттай үндэслэл байхгүй бусад тохиолдолд.

АЛБАН ТУШААЛТНУУД

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

34. ТУЗ-ийн анхны хурлаар захирлууд нь гишүүд дотроосоо Ерөнхийлөгчийг сонгоно. Ерөнхийлөгч нь ТУЗ-ийн гишүүн бол уг хурлын сонгуулийн дараа албан тушаалаа үргэлжлүүлэн хаших ба ийм сонгууль болоогүй тохиолдолд хурлын дараа албан тушаалаа үргэлжлүүлэн хашина. Ерөнхийлөгчийн суудал эзгүй үед түүнийг ТУЗ-ийн гишүүн орлоно. Түүнчлэн ТУЗ нь нарийн бичгийн даргыг томилох бөгөөд нэг буюу хэд хэдэн Дэд ерөнхийлөгч, Ерөнхий менежер, Ерөнхий нягтлан бодогч болон эдгээр албан тушаалтнуудын дор ажиллах нэг буюу хэд хэдэн туслах ажилтан зэрэг бусад ажилтныг тодорхойлон томилж болно. Ийнхүү томилогдсон Ерөнхийлөгчөөс бусад ажилтнууд нь ТУЗ-ийн гишүүн байж болох ч заавал гишүүн байх шаардлагагүй. Нэг хүн нэгээс олон албан тушаал хашиж болох ба нэг хүн Нарийн бичгийн дарга болон Ерөнхий нягтлан бодогчийн албыг давхар хаших тохиолдолд түүнийг Ерөнхий нягтлан бодогч-нарийн бичгийн дарга гэнэ.

АЛБА ХАШИХ ХУГАЦАА БА ЦАЛИН

35. Үүнээс өөрөөр бичгээр гэрээ үйлдээгүй тохиолдолд ТУЗ нь Корпорацийн аливаа албан тушаалтныг ажил үүргээс чөлөөлж болно. ТУЗ-өөс томилогдсон Ерөнхийлөгч ба бусад албан тушаалтнуудын албан тушаал эрхлэх хугацаа, цалингийн хэмжээг тухай бүрт ТУЗ тогтооно.

ТУЗ-ИЙН ДАРГА

36. ТУЗ-ийн дарга нь байгаа үедээ ТУЗ-ийн болон захирлуудын хороодын бүх хурлыг даргалах бөгөөд Ерөнхийлөгчийн эзгүйд хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална. Ерөнхий захирал томилогдоогүй байгаа тохиолдолд ТУЗ нь Ерөнхий захирлын эдлэх эрх, үүргийг энэхүү журмын дагуу ТУЗ-ийн даргад шилжүүлэх бөгөөд тэрбээр Канадын Бизнесийн байгууллагын хуульд заасны дагуу ТУЗ-өөс тодорхойлсон бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ. ТУЗ-ийн дарга эзгүй эсхүл ажил үүргээ гүйцэтгэх чадамжгүй болсон тохиолдолд түүний эрх, үүргийг Ерөнхий захирал (хэрэв байгаа бол) эсхүл Ерөнхийлөгч эдэлж, хэрэгжүүлнэ.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

37. Хэрэв Ерөнхий захирал байгаа бол тэр нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд, Корпорацийн албан үйл ажиллагаа, ажил хэргийг ерөнхий удирдлагаар хангаж, Канадын Бизнесийн байгууллагын хуульд заасан дагуу ТУЗ-өөс тодорхойлсон бусад эрх, үүргийг эдэлж, хэрэгжүүлнэ.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ЕРӨНХИЙЛӨГЧ

38. Ерөнхийлөгч нь байгаа үедээ хувьцаа эзэмшигчдийн бүх хуралд байлцаж, Корпорацийн албан үйл ажиллагаа, ажил хэргийг удирдан явуулах үүрэгтэй байна. ТУЗ-өөс ерөнхий менежер эсхүл ерөнхий захирал томилсноос бусад тохиолдолд Ерөнхийлөгч нь ерөнхий захирал эсхүл ерөнхий менежерийн эрх, үүргийг ч мөн эдэлж, хэрэгжүүлнэ.

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ

39. Ерөнхийлөгч эзгүй эсхүл ажил үүргээ гүйцэтгэх чадамжгүй болсон тохиолдолд түүний эрх, үүргийг Дэд ерөнхийлөгч эдэлж, хэрэгжүүлэх буюу нэгээс олон Дэд Ерөнхийлөгчтэй байх тохиолдолд ахлах эрэмбээр (үүнийг ТУЗ тогтооно) эдэлж, хэрэгжүүлэх бөгөөд Дэд ерөнхийлөгч нь захирлын хувьд ТУЗ-ийн хуралд оролцох шаардлага хангахгүй тул ТУЗ-ийн хурлыг даргалахгүй. Дэд Ерөнхийлөгч нь эзгүй эсхүл албан үүргээ биелүүлэх чадваргүй болсон Ерөнхийлөгчийн эрх, үүргийг орлон эдэлж, хэрэгжүүлнэ. Түүнчлэн Дэд ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчөөс эсхүл ТУЗ-өөс тухай бүрт даалгасан ажил үүргийг хэрэгжүүлж, олгосон эрх хэмжээг эдэлнэ.

ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР

40. Ерөнхий менежер (хэрэв томилогдох бол) нь Корпорацийн албан үйл ажиллагаа, ажил хэргийг (хууль, журмаараа ТУЗ ба/буюу хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэн гүйцэтгэх ёстой албан хэрэг, ажил үүргээс бусад) удирдан чиглүүлэх (ТУЗ-ийн шийдвэр, Ерөнхийлөгчийн удирдлага дор) ба ТУЗ-өөс шууд сонгоогүй буюу томилоогүй Корпорацийн аливаа албан тушаалтан, ажилтан, агентуудыг томилох, чөлөөлөх, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийн хугацаа, цалинг тогтоох эрхтэй байна. Ерөнхий менежер нь ТУЗ-д тайлагнах бөгөөд Корпорацийн үйл ажиллагаатай холбоотойгоор захирлуудын шаардсан бүхий л мэдээллийг тухай бүрт гаргаж өгнө. Агент эсхүл менежерийн томилсон агент эсхүл ажилтныг ТУЗ чөлөөлж болно. Ерөнхий менежер нь хэрэв захирал бол түүнийг Ерөнхий захирал гэж нэрлэж болох боловч шаардахгүй.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

41. Нарийн бичгийн дарга нь:

- а. Хувьцаа эзэмшигч, захирал, аудитор, хороодын гишүүдэд бүх мэдэгдлийг хүргэх буюу хүргүүлнэ;

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

- b. ТУЗ болон хувьцаа эзэмшигчдийн бүх хуралд байлцаж, хурлын бүртгэл тэмдэглэл хөтөлж, баримтжуулна;
- c. Корпорацийн тамга тэмдэг эсхүл байгууллагын тамга дарахад ашиглагдах механик хэрэгслүүд, Корпорацид харъяалагдах бүх бүртгэл, бичиг баримт, бусад хэрэгслүүдийг хадгална;
- d. ТУЗ-өөс тухай бүрт даалгах бусад үүргийг гүйцэтгэнэ.

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

42. Ерөнхий нягтлан бодогч нь:

- a. Корпорацийн орлого зарлагын бүртгэлийг үнэн зөв, бүрэн дүүрэн хөтлөх, ТУЗ-ийн тушаалаар мөнгөний хадгаламж, үнэт цаасны аюулгүй хадгалалт, Корпорацийн хөрөнгө зарцуулалтыг хийж гүйцэтгэнэ;
- b. ТУЗ-ийн хурал дээр эсхүл тухай бүрт шаардсан тохиолдолд Ерөнхий нягтлан бодогчийн бүх гүйлгээний данс бүртгэл, Корпорацийн санхүү байдлын талаарх мэдээллийг гаргаж өгнө;
- c. ТУЗ-өөс тухай бүрт даалгах бусад үүргийг гүйцэтгэнэ.

БУСАД АЛБАН ТУШААЛТНУУД

43. Корпорацийн бусад бүх албан тушаалтнууд нь ажлын байрны тодорхойлолтод заасан болон ТУЗ-өөс тухай бүрт шаардсан үүргийг гүйцэтгэнэ. Доороо туслах ажилтан томилуулсан албан тушаалтны эрх, үүргийг хэрэв ТУЗ-өөс өөрөөр шийдвэрлээгүй бол туслах ажилтан эдэлж, хэрэгжүүлж болно.

ЭРХ ҮҮРГИЙН ӨӨРЧЛӨЛТ

44. ТУЗ нь тухай бүрт аливаа албан тушаалтан эсхүл албан тушаалтнуудын эрх хэмжээ, ажил үүргийг өөрчилж, нэмж, хязгаарлаж болно.

АГЕНТ БА ӨМГӨӨЛӨГЧ

45. ТУЗ нь Канад улс дотор болон Канад улсаас гадна удирдлагын тодорхой эрх хэмжээ бүхий (тодорхой хэмжээний төлөөлөх эрх) эсхүл ийм шалгуурт нийцсэн аливаа агент, өмгөөлөгчийг тухай бүрт томилох эрхтэй байна.

ҮНЭНЧ БАЙДЛЫН ҮҮРЭГ АМЛАЛТ

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

46. ТУЗ нь Корпорацийн албан тушаалтан, ажилтнууд, агентуудаас тухай бүрт ТУЗ-өөс шаардсан хэлбэр, батлан даалтын дагуу албан үүргээ үнэнчээр биелүүлэх үүрэг амлалт гаргуулах эрхтэй. .

ХУВЬЦАА ХУВААРИЛАХ

47. ТУЗ нь Корпорацийн дүрмийн нэмэлт өөрчлөлтөөр бий болсон хувьцаа зэрэг Корпораци дахь зөвшөөрөгдсөн бөгөөд гаргаагүй хувьцааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авах опционыг ТУЗ-ийн шийдвэрээр тодорхойлсон этгээд, этгээдүүд эсхүл хэсэг бүлэг этгээдэд тухай бүрт хуваарилах буюу олгож болно.

ШИМТГЭЛ ТӨЛӨХ

48. Захирлууд сайн санааны үүднээс мөн Корпорацийн ашиг сонирхлыг дээд зэргээр харгалзан үзсэний үндсэн дээр Корпорациас Корпорацийн хувьцааг худалдан авах эсхүл худалдан авахыг зөвшөөрч буй эсхүл өөр бусад этгээдээс ийм хувьцаа худалдан авагчдыг олж холбосон эсхүл олж холбохыг зөвшөөрч буй аливаа этгээдэд шимтгэл төлөхийг Корпорацид зөвшөөрч болно.

ХУВЬЦААНЫ ГЭРЧИЛГЭЭ

49. Хувьцаа эзэмшигч бүр хувьцааг анх удаа гаргаж байгаа тохиолдолд төлбөр төлөхгүйгээр, харин Корпорацийн бүртгэлд үзүүлсэнчлэн өөрийн эзэмшилд буй хувьцааны дугаар, ангиллыг заасан хувьцааны гэрчилгээнд гурван (3) ам.доллараас ихгүй хэмжээний төлбөр төлөн дараачийн хувьцааг шилжүүлэн авах эрхтэй байна. Хувьцааны гэрчилгээний хэлбэр маягтыг тухай бүрт ТУЗ батална. ТУЗ-өөс өөрөөр шийдвэрлээгүй бол гэрчилгээнд Ерөнхийлөгч, эсхүл Дэд ерөнхийлөгч болон нарийн бичгийн дарга эсхүл туслах нарийн бичгийн дарга гарын үсэг зурах бөгөөд хувьцааг төлөөлөх гэрчилгээтэй холбоотойгоор томилогдсон шилжүүлгийн агент, бүртгэгч (салбарын шилжүүлгийн агент болон бүртгэгч багтана) нар эсхүл тэдгээрийн өмнөөс хоёрдугаар гарын үсэг зурсан бол хүчин төгөлдөр гэж үзэх тул Корпорацийн байгууллагын тамга дарах шаардлагагүй. ТУЗ-ийн шийдвэрээр зөвшөөрсөн тохиолдолд Корпорацийн тамга тэмдэг, гарын үсэг зурах албан тушаалтнуудын нэгийнх нь гарын үсгийг, эсхүл хувьцааг төлөөлөх гэрчилгээтэй холбоотойгоор шилжүүлгийн агент, бүртгэгч томилогдсон бол гарын үсэг зурах албан тушаалтнуудын бүгдийнх нь гарын үсгийг хувьцааны гэрчилгээн дээр хэвлэж, сийлж, барлаж, аль эсхүл факсаар механикаар үйлдэж болох бөгөөд факсаар ирүүлсэн гарын үсгийг тухайн албан

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

тушаалтны гарын үсэг гэж үзэх бөгөөд гэрчилгээ олгох өдрөөр эсхүл гэрчилгээ хүргүүлэх өдрөөр гэрчилгээн дээр гарын үсэг зурсан нэг эсхүл бүх албан тушаалтнууд албан үүрэг гүйцэтгэхээ больсон байсан ч гэрчилгээн дээр байнга тавигдах тэдний гарын үсгийг (гар бичмэл эсхүл факсдсан) хүчин төгөлдөр гэж үзнэ.

ХУВЬЦААНЫ ГЭРЧИЛГЭЭГ СОЛИХ

50. ТУЗ нь ерөнхийд нь эсхүл тодорхой тохиолдолд гэмтсэн гэрчилгээг цуцалсны үндсэн дээр эсхүл гээгдсэн, хулгайлагдсан болон устгагдсан гэрчилгээг орлох хувьцааны шинэ гэрчилгээ олгох шийдвэрийг нөхцөл байдлыг үндэслэн олгох шийдвэр гаргаж болно.

ТӨВИЙН БОЛОН САЛБАРЫН БҮРТГЭГЧ

51. Корпораци нь үнэт цаасны нэг төв бүртгэгчтэй байх ба тухай бүрт нэг буюу хэд хэдэн салбар бүртгэгчтэй болж болно. ТУЗ нь үнэт цаас эзэмшигчийг бүртгэх бүртгэгч, шилжүүлгийг бүртгэх шилжүүлгийн агентыг томилох шийдвэрийг тухай бүрт гаргах ба үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх нэг буюу хэд хэдэн салбарын бүртгэгч, шилжүүлэг бүртгэх нэг буюу хэд хэдэн салбар шилжүүлгийн агентуудыг томилж болно. Бүртгэгч болон шилжүүлгийн агент нь нэг хувь хүн эсхүл байгууллага байж болох ч шаардахгүй.

ҮНЭТ ЦААС ШИЛЖҮҮЛЭХ

52. Канадын Бизнесийн байгууллагын хуулинд заасны дагуу, Корпорацийн дүрэмд тодорхойлсон шилжүүлэгт тавигдах хязгаарлалтуудын хүрээнд зүй зохистойгоор баталгаажуулсан үнэт цаасыг Корпорацид шаардлагатай болж болохуйц нэмэлт баталгаажуулалтын хамтаар гаргаж өгөхтэй холбоотойгоор Корпорацид хадгалагдаж байгаа Корпорацийн үнэт цаасны шилжүүлэг нь шилжүүлгийн бүртгэгч эсхүл шилжүүлгийн салбар бүртгэгчдийн нэг дээр (хэрэв байгаа бол) бүртгэгдэх боломжтой байна.

БҮРТГЭГДСЭН ЭЗЭМШИГЧТЭЙ АРИЛЖАА ХИЙХ

53. Корпораци нь Канадын Бизнесийн байгууллагын хуулинд заасны дагуу үнэт цаасны бүртгэлд нэр дээр нь үнэт цаас бүртгэгдсэн этгээдийг үнэт цаасны эцсийн эзэмшигч гэж үзэх ба уг этгээд нь өөрийн бүртгэл, эсхүл үнэт цаасны гэрчилгээн дээр барьцаа, төлөөллийн эсхүл итгэл даах харилцаатай гэж

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

тэмдэглэгдсэн, өөр бусад хэрэгсэл болон өөр бусад этгээдийн эрхийг иш татсан зэрэг аливаа тайлбарыг үл харгалзан уг этгээдийг эрх зүйн бүрэн чадамжтай, эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх эрхтэй этгээд гэж үзнэ.

ХАМТРАН ЭЗЭМШИГЧ

54. Корпораци нь хэд хэдэн этгээдийн хамтран эзэмшиж буй үнэт цаасанд нэгээс (1) ихгүй гэрчилгээ гаргаж өгөх ба гэрчилгээг хэд хэдэн хамтран эзэмшигчийн нэгд (1) нь хүлээлгэн өгснийг гэрчилгээ хүлээлгэн өгсөнд тооцно. Хэрэв аливаа үнэт цаасны хамтран эзэмшигчээр хоёр (2) буюу түүнээс олон этгээд бүртгүүлсэн бол тэдгээрийн нэг нь хамтран эзэмшиж буй үнэт цаасны гэрчилгээ, мөн аливаа ногдол ашиг, урамшуулал, хөрөнгийн өгөөж, бусад мөнгөн төлбөр, тухайн үнэт цаастай холбоотойгоор олгогдох баталгаа зэргийг хүлээн авна.

БҮРТГЭЛИЙН ОГНОО

55. ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хүлээн авах эрх бүхий этгээдийг тодорхойлох бүртгэлийн өдрийг хурал болохоос жар (60) хоногоос ихгүй, эсхүл хорин нэгэн (21) хоногоос багагүй хугацааны өмнө урьдчилан тогтоох ба энэ тухай мэдэгдлийг Канадын Бизнесийн байгууллагын хуулинд заасан дагуу хүргүүлнэ. Хэрэв бүртгэлийн огноо тогтоогоогүй бол хурлын тухай мэдэгдэл хүлээн авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн огноо нь мэдэгдэл хүргүүлсэн өдрийн яг өмнөх өдрийн ажил тарах хугацаа байх ба мэдэгдэл өгөөгүй тохиолдолд хурал болох өдөр байна. Түүнчлэн ТУЗ нь ногдол ашиг авах, татан буугдсанаас үлдэх хөрөнгийг хуваан авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох, эсхүл хурал дээр санал өгөх мэдэгдлийг хүлээн авах эрхээс өөр бусад зорилготой бүртгэлийн огноог урьдчилан тогтоох ба тус огноо нь эдгээр үйл ажиллагаа болох өдрөөс өмнөх жар (60) хоногоос ихгүй байна.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

56. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-өөс тогтоосон Канад Улс доторх эсхүл Канад Улсаас гадуурзохион байгуулах ба хуралд саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигчид дараах зорилгоор жил бүрийн аль өдөр, цагт хуралдахыг ТУЗ-ийн тогтоолоор тогтоохыг зөвшөөрч байгаа болно. Үүнд:

- а. Жил бүрийн хурлын үеэр Канадын Бизнесийн байгууллагын хуулинд заасан дагуу хувьцаа эзэмшигчдийн өмнө танилцуулах тайлан, мэдэгдлийг хүлээн авч, сонсох;

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

- b. ТУЗ-ийн гишүүдийг сонгох;
- c. Шаардлагатай тохиолдолд аудиторыг томилох, түүний цалингийн хэмжээг тогтоох эрхийг ТУЗ-д олгох;
- d. Хурлын өмнө танилцуулах шаардлагатай бусад ажил хэргийн хэлцлүүд.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ

57. ТУЗ, Ерөнхийлөгч, захирал бөгөөд Дэд ерөнхийлөгч нь ТУЗ-өөс тогтоосон Канад Улс дах эсхүл Канад Улсаас гаднах газар, цагт зохион байгуулагдах Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн тусгай хурлыг аль ч үед зарлах эрхтэй бөгөөд үүнийг саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигч зөвшөөрсөн байна. Энэхүү журамд хэрэглэгдэх “хувьцаа эзэмшигчдийн хурал” гэх нэр томъёо нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлуудыг багтаасан ойлголт бөгөөд хувьцаа эзэмшигчдийн аливаа ангиллуудын хурлыг ч мөн энд хамруулан ойлгоно.

МЭДЭГДЭЛ

58. Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх мэдэгдэл, зар сурталчилгааг нийтэд мэдээлэх шаардлагагүй хэдий ч хурал болох газар, цагийн мэдээллийг хурал болох өдрөөс хорин нэг (21) хоногоос багагүй, жар (60) хоногоос ихгүй хугацааны дотор аудитор (хэрэв байгаа бол), захирлууд, энэхүү журмын 77 дугаар зүйлд заасан саналын эрхтэй хувьцаа эзэмшигч бүрт хүргүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдэлд хувьцаа эзэмшигчдэд санал, дүгнэлт гаргах боломж олгох үүднээс хурлаар хэлэлцэх асуудлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хурлаар хэлэлцүүлэх тусгай тогтоол, шийдвэрийн текстийн хамт дурдсан байна. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурал дээр санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчид бүгд бэлэн байгаа эсхүл итгэмжлэгдсэн төлөөллөөрөө дамжуулан мэдсэн, хурал хуралдуулахыг эсэргүүцээгүй, хуралд байлцаагүй, итгэмжлэгдсэн төлөөллөө ирүүлээгүй ч хурал хуралдуулахыг түдгэлзүүлэх саналгүй, аудитор (хэрэв байгаа бол) нь хуралд байлцсан бөгөөд эсэргүүцэх мэдэгдэл гаргаагүй тохиолдолд мэдэгдэл хүргүүлэхгүйгээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг аль ч цагт хуралдуулж болно. Ээлжит бус болон ээлжит хурлыг нэг дор нэг мэдэгдлийн дор хуралдуулж болох бөгөөд мэдэгдэл нь эхний хуралдааны олонхийн шаардлагаар батлагдаж буй аливаа тусгай шийдвэрт үндэслэн хоёр дахь хурлыг хуралдуулж байна гэх эсэргүүцэл төрүүлэхгүй байх шаардлагатай.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ТАЙЛАГНАХ

59. Канадын Бизнесийн байгууллагын хуулинд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн жил тутмын хурал болохоос эсхүл энэхүү журмын 73 дугаар зүйлд заасанчлан Корпорацийн жил тутмын үйл ажиллагааг хэлэлцэхээс өмнө хорин нэг (21) хоногоос хэтрэхгүй хугацаанд санхүүгийн тайлан, аудиторын (хэрэв байгаа бол) тайлангийн хувийг хувьцаа эзэмшигч бүрт илгээнэ.

БАЙЛЦАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

60. Хувьцаа эзэмшигчдийн хуралд байлцах эрх бүхий этгээд гэдэгт тус хурал дээр санал өгөх эрх бүхий этгээд, Корпорацийн аудитор (хэрэв байгаа бол), саналын эрхгүй ч Канадын Бизнесийн байгууллагын хууль, Корпорацийн дотоод журмын дагуу хуралд байлцах шаардлагатай буюу эрхтэй бусад этгээд батгана. Хурлын даргын урилгаар эсхүл хурлын бүрэлдэхүүний зөвшөөрлөөр өөр бусад этгээд хуралд байлцаж болно.

ХУРЛЫН ИРЦ

61. Тус бүр нь хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх эрхтэй, саналын эрхтэй хувьцааны таваас (5) багагүй хувийг эзэмшдэг буюу төлөөлдөг хоёр (2) хүн биеэр байлцаж хувьцаа эзэмшигчдийн хурал дээр асуудлыг хэлэлцэх ирцийг бүрдүүлнэ. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн аливаа хурлын нээлт дээр ирц бүрдсэн байвал хуралд ирсэн эсхүл төлөөлөл ирүүлсэн хувьцаа эзэмшигчид хурлын ирц хурлын туршид бүрэн биш байгааг үл харгалзан хурлын хэлэлцэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурлын нээлт дээр ирц бүрдээгүй бол хуралд ирсэн эсхүл төлөөлөл ирүүлсэн хувьцаа эзэмшигчид хурал болох газар, хугацааг хоушлуулан товлох боловч өөр бусад асуудлыг хэлэлцэхгүй.

САНАЛЫН ЭРХ

62. Энэхүү журмын 53 дугаар заалтын дагуу Корпорацийн бүртгэлд хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгөх эрхтэй нэг буюу түүнээс олон хувьцаа эзэмшигчээр бүртгүүлсэн, эсхүл бүртгэлийн өдөр товлогдсон бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос арав (10) хоногоос хэтрэхгүй хугацаанд тухайн этгээд нь Корпорацийн хувьцааг эзэмшдэг бөгөөд уг этгээдийн нэрийг хуралд санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад бүртгэхийг нотлох хангалттай баримтыг гаргаж өгсөн, хэрэв яригдаж байгаа хувьцааг моргэйж, "И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

зээлийн барьцаанд тавьсан бөгөөд моргэйж, зээлийн барьцаанд авсан этгээдэд хувьцааны саналын эрхийг өгөөгүй тохиолдолд хувьцааг моргэйж, зээлийн барьцаанд тавьсан этгээд (эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч) нь хуралд төлөөлж буй хувьцааны хэмжээгээр саналын эрхтэй байх бөгөөд энэ тохиолдолд хурлын Нарийн бичгийн даргад эдгээр хувьцаатай холбоотой хангалттай нотлох баримтыг гарган өгсөн хувьцаа эзэмшигчид (эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч) нь хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй байна.

ТӨЛӨӨЛӨГЧ

63. Гүйцэтгэгч, захирамжлагч, сэтгэцийн хувьд чадамжгүй этгээдийн хороо, асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөл, корпораци нь гүйцэтгэгч, захирамжлагч, хороо, асран хамгаалагч, гэрээслэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөл, гэрээслэл үйлдээгээгүй этгээд, сэтгэцийн хувьд чадамжгүй болсон этгээд, харгалзагч, хамтралын хувь эзэмшигч, корпорацийн бүрэн төлөөлөхөөр томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгч нь хурлын Нарийн бичгийн даргад өөрийн томилгоог хангалттай нотолж, Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн хуралд өөрийн эзэмшиж буй хувьцааг төлөөлж, хувьцаа эзэмшигчийн нэгэн адил саналын эрхтэй байна. Хэрэв нэгээс олон гүйцэтгэгч, захирамжлагч, хороо, асран хамгаалагч, итгэмжлэгдсэн төлөөлөгч байх тохиолдолд энэхүү журмын 65 дугаар заалт үйлчилнэ.

ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ

64. Бүх хувьцаа эзэмшигч (байгууллагын хувьцаа эзэмшигчийг оруулсан) нь хувьцаа эзэмшигч бус этгээдийг бичгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилж, хувьцаа эзэмшигчийн нэгэн адил эрх хэмжээтэйгээр итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрх хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож болно. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг түүнийг томилж буй этгээд эсхүл томилогч этгээдийн өмгөөлөгчийн бичгээр үйлдсэн итгэмжлэлийн үндсэн дээр томилох ба хэрэв томилогч этгээд нь корпораци бол байгууллагын тамга тэмдэг бүхий корпорацийн албан тушаалтан эсхүл түүний өмгөөлөгчийн бичгээр үйлдсэн итгэмжлэлийн үндсэн дээр томилох ба итгэмжлэлийн хүчинтэй хугацаа итгэмжлэл үйлдсэнээс хойш нэг жил байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох хэрэгслийг ТУЗ тухай бүрт тогтоох буюу хурлын даргын хангалттай гэж үзсэн хэлбэрээр байж болох ба энэ дагуу санал хураахын өмнө эсхүл Канадын Бизнесийн байгууллагын хуульд заасны дагуу ТУЗ-ийн үүнээс өмнө тогтоосон цагт хурлын Нарийн бичгийн даргад тухайн хэрэгслийг хадгалуулна.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ХАМТАРСАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

65. Хэрэв хувьцааг хоёр (2) буюу түүнээс олон этгээд хамтран эзэмшиж байгаа тохиолдолд Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн хуралд бусад эзэмшигчдээ эзгүйд тэдний нэг (1) эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч байлцаж, саналаа өгч болох ба тэдний нэгээс олон эзэмшигч хуралд байлцах буюу итгэмжлэгдсэн төлөөлөгчөө оролцуулах бол хамтран эзэмшиж буй хувьцааны үндсэн дээр хамтдаа нэг (1) санал өгнө.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

66. Корпорацийн Ерөнхийлөгч, түүний эзгүйд ТУЗ-ийн дарга (хэрэв ийм албан тушаалтан сонгогдож, томилогдсон бөгөөд одоо байгаа бол), эсхүл Корпорацийн хувьцаа эзэмшигч болох дэд ерөнхийлөгч нь Хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална. Хувьцаа эзэмшигчдийн хурал эхлэхээр тогтсон цагаас өмнөх арван таван (15) минутын дотор ийм албан тушаалтан байхгүй байх тохиолдолд хуралд ирсэн бөгөөд саналын эрхтэй этгээдүүд дотроосоо нэг этгээдийг сонгоно. Хэрэв Корпорацийн Нарийн бичгийн дарга эзгүй байх тохиолдолд хурлын Дарга заавал хувьцаа эзэмшигч байх албагүй нэг этгээдийг хурлын Нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгүүлэхээр томилно.

САНАЛ ТООЛОГЧ

67. Хувьцаа эзэмшигчдийн хурал бүрт хурлын шийдвэрээр эсхүл хуралд оролцогчдын зөвшөөрлөөр хурлын Дарга нэг (1) буюу хэд хэдэн санал тоологч томилж болно. Санал тоологч нь Корпорацийн хувьцаа эзэмшигч байх шаардлагагүй.

САНАЛААР ШИЙДВЭРЛЭХ

68. Хувьцаа эзэмшигчдийн хурал бүрт хуулиар эсхүл Корпорацийн энэхүү журмаар шаардсанаас бусад бүх асуудлыг тухайн асуудлаар өгсөн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

ГАР ӨРГӨХ

69. Хувьцаа эзэмшигчдийн хурал бүрт хурлын дарга санал хураалт явуулахыг шаардах эсхүл өөрийн биеэр хуралд байлцаж буй эсхүл итгэмжлэгдсэн "И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

төлөөлөгчөөрөө дамжуулан санал өгөх эрхтэй аливаа хувьцаа эзэмшигч шаардсанаас бусад тохиолдолд асуудлыг гар өргөх зарчмаар шийдвэрлэнэ. Өөрийн биеэр хуралд байлцаж, санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигч бүр гар өргөснөөр нэг санал өгөх бөгөөд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж байгаа хувьцаа эзэмшигч саналын эрхгүй байна. Аливаа асуудлаар гар өргөсний дараа хурлын Дарга эсхүл өөрийн биеэр байлцаж байгаа эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хуралд санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн шаардсанаар нууц санал хураалт явуулж болно. Нууц санал хураалт явуулахыг шаардаагүй бол тухайн асуудлаар гар өргөх зарчмаар санал хураасан тохиолдолд тухайн асуудлаар санал хураалт явагдсан; тодорхой олонхийн саналаар явагдсан эсхүл явагдаагүй болохыг зарлах ба энэ талаар хурлын тэмдэглэлд оруулах мэдээлэл нь дээр дурдсан асуудлаар бусад хурал; аливаа шийдвэрийг дэмжсэн эсхүл эсэргүүцсэн саналын хувь хэмжээг нотлох нотолгоогүй баримтын анхан шатны нотолгоо болох бөгөөд ээлжит болон ээлжит бус хурал дээр тухайн асуудлаарх саналын үр дүнг Корпорацийн шийдвэр гэж үзнэ. Нууцаар санал хураалт явуулахаас өмнөх аль ч үед нууцаар санал хураалт явуулах тухай шаардлагыг буцааж болно.

НУУЦ САНАЛ ХУРААЛТ

70. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нууц санал хураалт явуулах шаардлагатай гэж үзсэн; аливаа хувьцаа эзэмшигч нууц санал хураалт явуулахыг шаардсан бөгөөд уг шаардлагаа буцааж аваагүй тохиолдолд хурлын даргын удирдлага дор тухайн асуудлаар нууц санал хураалт явуулна. Нууц санал хураалтаар хуралд өөрийн биеэр байлцаж буй эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож буй хувьцаа эзэмшигч бүр эзэмшиж буй хувьцаа тутамд нэг санал өгөх эрхтэй байх ба нууц санал хураалтын үр дүн нь тухайн асуудлаарх хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр байна. Нууц санал хураалт явуулахыг шаардсан эсхүл явуулах шаардлагатай болсон нь хурлыг үргэлжлүүлэх; нууц санал хураалт явуулах шаардлагатай эсхүл явуулахыг шаардсан асуудлаас бусад албан хэргийг хэлэлцэхэд саад болохгүй.

ШИЙДВЭРЛЭХ САНАЛ

71. Хувьцаа эзэмшигчдийн хурал дээр гар өргөх зарчмаар санал хураах эсхүл нууц санал хураалт явуулсны дүнд санал тэнцсэн тохиолдолд хурлын дарга хоёр дахь эсхүл шийдвэрлэх санал хураалт явуулах эрхтэй байна.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ХУРЛЫГ ХОЙШЛУУЛАХ

72. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга хурлын зөвшөөрлөөр болон хурлын шийдвэрлэж болох нөхцөл байдлыг харгалзан хурлын байршил, хугацааг тухай бүрт хойшлуулж болно. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурлыг гуч (30) хоногоос ихгүй хугацаагаар хойшлуулсан бол хурал хойшлогдсоныг зарлахаас өөрөөр хурал хойшлогдсон тухай мэдүүлэг хүргүүлэх шаардлагагүй. Хэрэв хувьцаа эзэмшигчдийн хурлыг нэг буюу түүнээс олон удаа нийт гуч (30) хоног буюу түүнээс дээш хугацаагаар хойшлуулсан тохиолдолд анхны хурлын мэдэгдэл хүргүүлсний адил хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг ч мөн хүргүүлнэ. Ер (90) хоног буюу түүнээс дээш хугацаагаар хойшлуулсан бол Канадын Бизнесийн байгууллагын хуулийн 149 дүгээр зүйлийн (1) дүгээр хэсэг үйлчлэхгүй. .

ШИЙДВЭРИЙГ ГАРЫН ҮСГЭЭР БАТАЛГААЖУУЛАХ

73. Канадын Бизнесийн байгууллагын хуулийн заалт ёсоор саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигч гарын үсэг зурсан хувьцаа эзэмшигчдийн хурлын бичгээр үйлдсэн шийдвэр, Канадын Бизнесийн байгууллагын хуулийн дагуу шаардсан бүх асуудлыг хэлэлцсэн бичгээр үйлдсэн шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж, саналын эрхтэй бүх хувьцаа эзэмшигч тус шийдвэрт гарын үсэг зурснаар шийдвэр нь хууль ёсоор зарлагдан хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлаас батлагдсан хүчин төгөлдөр шийдвэр болно. Бичгээр үйлдсэн ийм шийдвэрийн хувийг хурлын тэмдэглэлийн хамт хадгална. Тухайн шийдвэрт хэзээ гарын үсэг зурсан, олон хувиар үйлдсэн эсэхээс үл хамаарч тус шийдвэр нь шийдвэрт заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

ГАНЦ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

74. Корпораци нь зөвхөн ганц (1) хувьцаа эзэмшигчтэй бол Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн жилийн болон тусгай хурлаар хэлэлцэх асуудлыг энэхүү журмын 73 дугаар заалтад заасан дагуу шийдвэрлэнэ.

НОГДОЛ АШИГ БОЛОН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ОГНОО

75. Канадын Бизнесийн байгууллагын хуулийн дагуу эрхээсээ татгалзаагүй бол бүртгэл хийгдэх өдрөөс долоогоос (7) багагүй өдрийн өмнө мэдэгдлийг сонины зар болон Канадын Бизнесийн байгууллагын хуульд заасан дагуу

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

хүргүүлсэн, Корпорацийн хувьцааг арилжаалахаар бүртгүүлсэн Канад дахь хөрөнгийн бирж бүрт (хэрэв байгаа бол) бичгээр мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд ТУЗ нь аливаа ногдол ашиг төлөх өдрөөс өмнөх жараас (60) ихгүй хоногийн дотор ногдол ашгийн төлбөр авах эрх бүхий этгээдийг тодорхойлох бүртгэлийн огноог урьдчилан тогтооно. Дээр дурдсанчлан бүртгэлийн огноог урьдчилан тогтоогоогүй тохиолдолд ногдол ашгийн төлбөр авах эрх бүхий этгээдийг тодорхойлох бүртгэлийн огноо нь ТУЗ-өөс гаргасан ийм ногдол ашигтай холбоотой шийдвэрт заасан өдрийн ажил дуусах хугацаа байна.

НОГДОЛ АШИГ

76. ТУЗ нь Корпорацийн хэмжээнд эдлэх эрх, ашиг сонирхлын нь дагуу хувьцаа эзэмшигчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тухай бүрт зарлана. Бэлэн мөнгөөр төлөх ногдол ашгийн төлбөрийг Корпорацийн харилцагч банкны чекээр олгох буюу банкуудын нэг нь тухайн ангилалын хувьцааны бүртгэлтэй эзэмшигчийн захиалгаар зарлагдсан ногдол ашгийг Корпорацийн бүртгэлд хувьцаа эзэмшигчийн хамгийн сүүлд бүртгүүлсэн хаягруу энгийн шуудан, урьдчилсан төлбөрт шуудангаар илгээнэ. Хамтарсан хувьцаа эзэмшигчид өөрөөр хүсэлт гаргаагүй бол тэдний ногол ашгийн чекийг хамтарсан бүх хувьцаа эзэмшигчдийн захиалгаар төлөх бөгөөд хэрэв Корпорацийн бүртгэлд хамтарсан хувьцаа эзэмшигчдийн нэгээс олон хаяг байгаа тохиолдолд чекийг тус бүртгэл дээрх хамгийн эхний хаягруу шуудангаар илгээнэ. Дээр дурдсанчлан чекийг шуудангаар илгээх бол ийм чекийг нэрлэсэн үнээр илэрхийлж төлөх тохиолдолд чек дээр илэрхийлсэн дүн хэмжээ нь ногдол ашгийн хэмжээтэй тохирч байх ёстой. Дээр дурдсан байдлаар илгээсэн ногдол ашгийн чекийг хувьцаа эзэмшигч хүлээн аваагүй тохиолдолд Корпораци нь ийн хүлээн аваагүй болохыг нотлох баримтад тулгуурлан зохих нөхөн олговрыг төлж барагдуулах үүднээс тухайн этгээдэд ижил дүн бүхий орлох чекийг олгоно. Холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдол ашгийн төлбөр төлөхөөр зарласан өдрөөс хойш зургаан (6) жилийн дотор ногдол ашгийн төлбөрөө нэхэмжлээгүй тохиолдолд тус төлбөр нь Корпорацийн өмч болно.

МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ АРГУУД

77. Корпорациас дүрэм болон энэхүү журмын хүрээнд Корпорацийн хувьцаа эзэмшигч, захирал, албан тушаалтан, аудиторт хүргүүлэх аливаа мэдэгдэл, захидал харилцаа, өөр бусад албан бичгийг гарт нь биечлэн хүргүүлэх, эсхүл Корпорацийн бүртгэлийн дэвтэрт сүүлчийн байдлаар тэмдэглэгдсэн хаягт хүргүүлэх буюу Корпорацийн бүртгэлийн дэвтэрт сүүлчийн байдлаар тэмдэглэгдсэн хаягт хаяглан битүүмжилсэн дугтуйнд хийн урьдчилсан

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

төлбөрт энгийн шуудангаар илгээх, эсхүл утаст болон утасгүй харилцаа холбооны хэрэгсэл ашиглан илгээнэ. Нарийн бичгийн дарга нь Корпорацийн бүртгэлийн дэвтэр дэх хувьцаа эзэмшигчийн хаягийг найдвартай гэж үзсэн мэдээллийнхээ дагуу өөрчилж болно. Ийнхүү хүргүүлсэн мэдэгдэл, захидал харилцаа, албан бичгийг гарт нь хүргэсэн, эсхүл дээрх хаягаар хүргүүлснийг зохих эзэндээ хүрсэн гэж үзнэ. Шуудангаар илгээсэн мэдэгдэл, захидал харилцаа, албан бичгийг шуудан эсхүл шуудангийн хайрцагт хийснийг зохих эзэндээ хүрсэн гэж үзнэ. Утсан болон утасгүй харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан илгээсэн мэдэгдэл, захидал харилцаа, албан бичгийг зохих харилцаа холбооны компани, агентлаг эсхүл түгээлтийн төлөөлөгчид хүргүүлснийг зохих эзэндээ хүрсэн гэж үзнэ.

ХУГАЦАА ТООЦООЛОЛ

78. Аливаа хурал, арга хэмжээний тухай мэдэгдлийг тодорхой тооны өдөр гаргахыг шаардсан Дүрмийн заалт, энэхүү журмын дагуу мэдэгдэл хүргэгдсэн байх хугацааг тооцоолохдоо мэдэгдэл хүргэх огноо, хурлын эсхүл бусад арга хэмжээний огноог хасч тооцно.

ЭС ҮЙЛДЭХҮЙ БА АЛДАА

79. Аливаа хувьцаа эзэмшигч, захирал, албан тушаалтан эсхүл аудиторт мэдэгдэл хүргүүлэхдээ санамсаргүй эс үйлдэл хийх, мэдэгдэлд агуулгад нөлөөлөхгүй алдаа гаргасан нь ийм мэдэгдлийн дагуу буюу үүнд үндэслэн хийсэн аливаа хурал дээр авсан арга хэмжээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

ХАМТАРСАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ

80. Корпорацийн бүртгэлийн дэвтэрт хамтран эзэмшилтэй холбогдох нэгээс олон хаяг бүртгэлтэй бол нэгээс олон нэр дээр бүртгүүлсэн аливаа хувьцаатай холбоотой мэдэгдлийг бүртгэл дээрх эхний хаяг дээрх хамтран эзэмшигчид хүргүүлэх ба ийнхүү мэдэгдэл хүргүүлсэн нь ийм хувьцааны бүх эзэмшигчдэд хамаарна.

НАС БАРСАН ЭТГЭЭДИЙН ЭСХҮЛ ХУУЛЬД ЗААСАН ЭЗЭМШИГЧИЙН ЭРХЭЭС ҮЛ ШАЛТГААЛАН ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

81. Хувьцаа эзэмшигч нас барсан эсхүл ямар нэгэн байдлаар хуульд заасан эзэмшигчийн эрхээс үл шалтгаалан эрх шилжүүлэн авсан этгээд нь Корпорацийн бүртгэлийн дэвтэрт (эрх шилжүүлэн авахтай холбоотой үйл явдал болохоос өмнө эсхүл болсны дараа) бүртгэлтэй эрх шилжүүлж өгсөн этгээдийн нэр, хаягт бүртгэлтэй хувьцаа эсхүл хувьцаануудыг бүрэн дүүрэн эзэмших эрхтэй болж ийм хувьцаатай холбоотой мэдэгдлийн дагуу үүрэг хүлээнэ.

МЭДЭГДЭЛ ХҮЛЭЭН АВААГҮЙ БАЙХ

82. Энэхүү журмын дагуу хувьцаа эзэмшигчид илгээсэн мэдэгдэл эсхүл баримт бичиг нь хувьцаа эзэмшигч олдохгүйгээс шалтгаалан гурван (3) удаа дараалан буцаж ирсэн тохиолдолд хувьцаа эзэмшигч шинэ хаягаа бичгээр мэдэгдэх хүртэл Корпораци тус хувьцаа эзэмшигчид дахин мэдэгдэл, албан бичиг илгээх шаардлагагүй. Гэхдээ хувьцаа эзэмшигчид шуудангаар илгээсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын тухай мэдэгдэл буцаж ирсэн тохиолдолд буцаж ирснээс үл хамааран шууданд хадгалагдаж байсан ч хувьцаа эзэмшигч уг мэдэгдлийг хүлээн авсан гэж үзнэ.

МЭДЭГДЭЛ ДЭЭРХ ГАРЫН ҮСЭГ

83. Хэрэв өөрөөр тусгайлан заагаагүй бол Корпорациас гарах аливаа мэдэгдэл, баримт бичигт зурах захирал эсхүл албан тушаалтны гарын үсэг нь бичмэл, дардсан, хэвлэмэл эсхүл хэсэгчилсэн байдлаар бичмэл, хэвлэмэл, дардсан гарын үсэг байж болно.

МЭДЭГДЛЭЭС ТАТГАЛЗАХ

84. Корпорацийн дүрэм, энэхүү журам, эсхүл Канадын Бизнесийн байгууллагын хуулийн заалтын дагуу өгөх шаардлагатай аливаа мэдэгдлээс хувьцаа эзэмшигч (эсхүл түүний бүрэн итгэмжит төлөөлөгч), захирал, албан тушаалтан, аудитор татгалзсан бөгөөд мэдэгдэл өгөх шаардлагатай хурал, арга хэмжээний өмнө эсхүл дараа ийнхүү татгалзсан эсэхээс үл хамаарч ийм мэдэгдэл өгөхөд гарсан аливаа зардлыг хариуцна.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ТУСГААР БАЙДАЛ

85. Энэхүү журмын аливаа заалт хүчин төгөлдөр бус эсхүл сахиулах боломжгүй болсон нь тус журмын үлдэх заалтуудын хүчин төгөлдөр байдал, сахиулах боломжтой байдалд нөлөөлөхгүй.

ТАЙЛБАР

86. Корпорацийн энэхүү журам болон бусад бүх журамд:

- a. Ганц тоогоор олон тоог, олон тоогоор ганц тоог төлөөлүүлснийг;
- b. Эрэгтэй хүйсээр эмэгтэй болон саармаг хүйсийг төлөөлүүлснийг;
- c. Этгээд гэж компани, корпораци, нөхөрлөл, аливаа нэгдмэл бүлэг этгээдийг;
- d. “Канадын улсын иргэн” гэж Канадын Бизнесийн байгууллагын хуулинд тодорхойлсон дагуу Канад улсын иргэнийг;
- e. “Дүрэм” эсхүл “зүйл” гэж корпорацийн дүрмийн эх эсхүл дахин засварлагдсан хувь, нэмэлт өөрчлөлтийн дүрэм, нэгдэлтийн дүрэм, тасралтгүй байдлын дүрэм, дүрэм эсхүл дахин зохион байгуулалт, татан буулгах дүрэм, шинэчлэлтийн дүрэм, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг;
- f. “Хууль” эсхүл “Канадын Бизнесийн байгууллагын хууль” гэж тухай бүрт нэмэлт өөрчлөлт орох Канадын Бизнесийн байгууллагын хууль, цаашид түүнийг орлох аливаа хуулийг гэж тус тус ойлгоно.

2003 оны 10 дугаар сарын 22-ны өдөр БАТЛАВ.

Корпорацийн байгууллагын тамга тэмдгийг ГЭРЧИЛЖ

“гарын үсэг зурсан”

Петер С. Акерлей, Ерөнхийлөгч

“гарын үсэг зурсан”

Д.Сюзан Фрейзер, Нарийн бичгийн дарга

ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Корпораци байгуулагдах үед батлагдсан Дотоод журам 1-ийг хүчингүй болсонд тооцож, Корпорацийн албан хэлцэл гүйлгээ, ажил хэрэгт ерөнхийд нь хамаарах Дотоод журам 1-ийг үүгээр батласугай. Корпорацийн Ерөнхийлөгч болон Нарийн бичгийн дарга нар энэхүү журамд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарах эрхтэй болно.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: **89100044**; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN**

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ШИЙДВЭРЛЭХ НЬ:

Корпорацийн хувьцаа эзэмшигчдийн 2003 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн Жилийн болон тусгай хурлаар Корпорацийн албан хэлцэл гүйлгээ, ажил хэрэгт ерөнхийд нь хамаарах Дотоод журам 1-ийг аливаа нэмэлт өөрчлөлтгүйгээр энэ хэвээр нь Корпорацийн дотоод журам болгон батласугай.

2003 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр

гарын үсэг зурсан”
Д.СЮЗАН ФРЕЙЗЕР, Нарийн бичгийн дарга

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

ДОТООД ЖУРАМ 1-Д ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

Хувьцаа эзэмшигчдийн дараачийн хурлаар баталгаажуулах доорх 10А хэсгийг Корпорацийн Дотоод журам 1-д үүгээр нэмж оруулж байгаа ба 2013 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

ЗАХИРЛУУДЫГ НЭР ДЭВШҮҮЛЭХ

10А.

- а) **Нэр дэвшүүлэх үйл явц.** Хууль болон Корпорацийн дүрмийн дагуу дараах аргачлалын дагуу нэр дэвшүүлээгүй тохиолдолд нэр дэвшигч нь Корпорацийн захирал болох эрхгүй байна. Хувьцаа эзэмшигчдийн жилийн хурал дээр эсхүл дараах этгээдийн зарласан тусгай хурлын зорилгуудын нэг нь захирлуудыг сонгох бол тусгай хурал дээр ТУЗ-д сонгогдох этгээдийг нэр дэвшүүлнэ. Үүнд:
- i. Хурлын мэдэгдлийн дагуу Зөвлөл, эсхүл Зөвлөлийн шаардлагаар;
 - ii. Хуулийн заалтын дагуу гаргасан саналын хүрээнд нэг эсхүл хэд хэдэн хувьцаа эзэмшигч, эсхүл тэдгээрийн хүсэлт, шаардлагаар, эсхүл Хуулийн заалтын дагуу гаргасан хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар;
 - iii. Аливаа этгээд (“**Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч**”) буюу:
 - a. Энэхүү 10А хэсэгт заасан дагуу мэдэгдэл хүргүүлсэн өдрийн ажил тарах цагт, ийм хурлын мэдэгдэл гаргасан бүртгэлийн өдөр ийм хуралд саналын эрх бүхий нэг буюу түүнээс олон хувьцаа эзэмшигчээр бүртгэгдсэн эсхүл ийм хуралд санал эрх бүхий хувьцааг давуу эрхтэйгээр эзэмшдэг этгээд
 - b. Энэхүү 10А хэсэгт тодорхойлсон мэдэгдлийн аргачлалыг хангасан этгээд байна.
- б) **Хугацаат мэдэгдэл.** Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нэр дэвшүүлэхэд өөр бусад холбогдох шаардлага тавигдахаас гадна Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нь Корпорацийн төв оффист байрлах Корпорацийн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэлтийн хугацаат мэдэгдлийг зүй зохистой бичгэн хэлбэрээр хүлээлгэн өгнө.
- с) **Хугацаат мэдэгдэл гаргах.** Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нь Корпорацийн Нарийн бичгийн даргад хугацаат мэдэгдлийг дараах тохиолдолд өгнө. Үүнд:

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

- i. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хувьд хурал болохоос өмнөх 30 хоногоос багагүй, 65 хоногоос ихгүй хугацаанд, гэхдээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай олон нийтэд анх зарласан өдрөөс хойш тавин (50) өдрөөс багагүй хугацааны (“Мэдэгдлийн өдөр”) дотор хурал хуралдах гэж буй тохиолдолд Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нь мэдэгдлийн өдрөөс хойшхи арав дахь (10) өдрийн бизнес хаагдах өдрөөс хэтрэлгүй мэдэгдэл өгнө.
- ii. Захирлуудыг сонгох хувьцаа эзэмшигчдийн тусгай хурал (жилийн хурал бус) зарлагдсан тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн тусгай хурлыг хуралдуулах тухай олон нийтэд анх зарласан өдрөөс хойшхи арван тав дахь (15) өдрийн ажлын цаг дуусахаас хэтрэлгүй мэдэгдэл өгнө.

Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигчийн мэдэгдэл өгөх дээр дурдсан хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн хурал эсхүл хурлын зар хойшлогдсоноос шалтгаалан өөрчлөгдөхгүй.

- d) **Хугацаат мэдэгдлийн тохиромжтой загвар.** Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч нь Корпорацийн нарийн бичгийн даргад дараах зүйлсийг тодорхойлсон зүй зохистой маягтаар бэлтгэсэн мэдэгдлийг бичгээр өгнө. Үүнд:

- (i) Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигч захирлын сонгуульд нэр дэвшүүлэх этгээдийн дараах мэдээллийг тодорхойлсон байна. Үүнд:
 - a. Тухайн этгээдийн нэр, нас, ажлын хаяг, оршин суугаа хаяг;
 - b. Тухайн этгээдийн үндсэн мэргэжил, эрхэлж буй ажил;
 - c. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүртгэлийн өдөр (хэрэв ийм өдрийг олон нийтэд зарласан, ийм өдөр болсон бол), ийм мэдэгдэл хүргүүлсэн өдрөөр тухайн этгээдийн хяналтад байдаг, эзэмшиж байгаа эсхүл бүртгэгдсэн Корпорацийн хөрөнгөд эзлэх хувьцааны тоо, дугаар, ангилал;
 - d. Хууль болон Үнэт цаасны үйлчлэх хууль (доор тодорхойлсончлон)-ийн дагуу захирлуудын сонгуульд гаргасан итгэмжлэлийн хүсэлттэй холбоотойгоор саналын зөрүүний тайланд хавсаргах шаардлагатай тухайн этгээдтэй холбоотой бусад мэдээллүүд.
- (ii) Хууль болон Үнэт цаасны үйлчлэх хууль (доор тодорхойлсончлон)-ийн дагуу захирлуудын сонгуульд гаргасан итгэмжлэлийн хүсэлттэй холбоотойгоор саналын зөрүүний тайланд хавсаргах шаардлагатай Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Корпорацийн аливаа саналын эрхтэй хувьцаатай холбоотой аливаа итгэмжлэл, гэрээ, зохицуулалт, ойлголцол, харилцаа болон Нэр дэвшүүлж буй хувьцаа эзэмшигчтэй холбоотой аливаа бусад мэдээлэл.

Корпораци нь санал болгож буй аливаа нэр дэвшигчээс тухайн нэр дэвшигч нь Корпорацийн хараат бус, бие даасан захирал болох шаардлагыг хангасан

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

эсэхийг тодорхойлох эсхүл санал болгож буй нэр дэвшигчийн хараат бус байдлын талаар хувьцаа эзэмшигчид ойлголт өгөх үүднээс Корпорацид шаардагдаж болох бичгээр үйлдсэн зөвшөөрөл гэх мэт бусад мэдээллийг аливаа нэр дэвшигчээс шаардаж болно.

- e) **Захирлаар нэр дэвшихэд тавигдах шаардлага.** Энэхүү 10А хэсгийн заалтуудын дагуу нэр дэвшээгүй аливаа этгээд Корпорацийн захирлын сонгуульд оролцох эрхгүй байна. Гэхдээ 10А хэсэгт заасан аливаа заалтыг хувьцаа эзэмшигч нь (захирлуудад нэр дэвшигчээс өөр) хувьцаа эзэмшигчдийн хурал дээр Хуулийн зүйл заалтын дагуу санал гаргах эрх бүхий аливаа асуудлыг хэлэлцүүлэх явдлыг хориглосон заалт гэж үзэхгүй. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга нь нэр дэвшүүлэх үйл явц дээр дурдсан аргачлалын дагуу явагдсан эсэхийг тодорхойлж, хэрэв санал болгосон нэр дэвшигч нь дээрх аргачлалын дагуу нэр дэвшээгүй бол ийм доголдолтой нэр дэвшигчийг хасахыг мэдэгдэнэ.
- f) **Нэр томъёо.** 10А хэсэгт ашигласан дорх нэр томъёог дараах утгаар ойлгоно.
Үүнд:
- (i) “**олон нийтэд зарлах**” гэж Канад дахь үндэсний мэдээллийн сувгаар мэдээнэвтрүүлэх, эсхүл Цахим баримт бичгийн дүн шинжилгээ, хандалтын систем болох www.sedar.com цахим хуудсанд байрлах Корпорацийн танилцуулгын дор олон нийтэд зориулсан албан мэдээ нийтлэхийг;
 - (ii) “**Үнэт цаасны үйлчлэх хууль**” гэж Канад улсын нутаг дэвсгэр, харъяалагдах муж бүрт үйлчлэх, тухай бүрт нэмэлт өөрчлөлт орох үнэт цаасны хууль тогтоомж, ийм хууль тогтоомжийн хүрээнд боловсруулан мөрдүүлэх дүрэм, журам, маягт, үндэсний хэвлэмэл хэрэгслүүд, олон талт хэрэгслүүд, бодлого, бюллетин, болон Канадын муж, газар нутаг бүрийн үнэт цаасны хороо, түүнтэй адилтгах зохицуулагч байгууллагын мэдэгдлүүдийг.
- g) **Мэдэгдэл хүргүүлэх.** Энэхүү журмын өөр бусад заалтаас үл хамааран 10А хэсгийн дагуу Корпорацийн Нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлэхдээ зөвхөн биечлэн гарт нь, факсаар эсхүл цахим (и-мэйл) шуудангаар (ийм мэдэгдэл хүлээн авах зорилгоор Корпорацийн Нарийн бичгийн даргын тухай бүрт тогтоосон цахим шуудангийн хаягруу) илгээх бөгөөд Корпорацийн төв байрны хаягаар Нарийн бичгийн даргад биечлэн хүргүүлсэн, цахим шуудангаар илгээсэн (дээр дурдсан хаягруу) эсхүл факсаар дамжуулсныг (ийнхүү факсаар илгээснийг хүлээн авсан болохоо баталгаажуулсан баримтыг хүлээн авсан байх) мэдэгдэл хүргэгдсэн гэж үзэх ба хэрэв ажлын бус өдөр эсхүл ажлын өдөр оройн 5:00 цагаас (Халифаксын цагаар) хойш цахим харилцаа холбоогоор мэдэгдэл илгээсэн бол тухайн мэдэгдлийг дараачийн ажлын өдөр нь хүргэгдсэн гэж үзнэ.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

Утас: 89100044; E-mail: INFO@ORCHUULGA24.MN

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency

- h) **ТУЗ-ийн шийдвэр.** Дээр дурдсанаас үл хамааран ТУЗ нь зөвхөн өөрийн үзэмжээр энэхүү 10А хэсэгт тодорхойлсон шаардлагуудаас татгалзаж болно.

Тухай бүрт нэмэлт өөрчлөлт орж болох Корпорацийн Дотоод журам 1-д тодорхойлсон, энэхүү нэмэлт өөрчлөлтөд агуулагдах бүх нэр томъёо нь Дотоод журам 1-д тодорхойлсон утгаар энд ашиглагдана.

"И ЭФ СИ" ХХК-ний дэргэдэх Орчуулгын Төвөөр Англи хэлнээс Монгол хэл рүү хөрвүүлэн, баталгаажуулав.

*Утас: 89100044; E-mail: **INFO@ORCHUULGA24.MN***

Огноо: 2018.03.28

www.facebook.com/AllinOneSpotYourTranslationAgency